

БАРУУН ОРОНД БУРХНЫ ШАШИН ТОРГОНЫ ЗАМААР ДАМЖИН НЭВТЭРСЭН ТОВЧ ТҮҮХ

Т.Чулуун-Эрдэнэ (Ph.D)

Гадаад Хэлний тэнхим.

Гадаад хэлний сургууль, ХУИС.

Түлхүүр үг: Торгоны зам, баруун орон, Бурханы шашин, Хятадын түүх.

Товч утга: 2014 онд БНХАУ-ын дарга Ши Жинпинь “Нэг бүс, нэг зам” санаачлагыг дэвшүүлснээс хойш эртний торгоны зам, түүний түүхэн ундарга болох баруун орны тухай судалгаа гадна дотны эрдэмтэн судлаачдын анхаарлыг ихэд татаж, торгоны зам судлалын хүрээ олон улсад өндөр байр суурь эзэлж байна.

Торгоны зам бол Хятадын Баруун, Зүүн Хань төрт улсын үед үүссэн, эртний хийгээд дундад зууны үед Шар мөрөн, Хөх мөрний сав газраас торгыг гол худалдааны эд таваар болгож, Энэтхэг, Дундад Ази, баруун Азиар дайран, Хойд Африк болон Европ тивд хүрдэг байсан худалдааны чухал зам бөгөөд өрнө дорнын улс үндэстнүүдийн соёлын харилцааны гол гүүр, бурхны шашин баруунаас дорно зүгт дэлгэрсэн гол гарц билээ. Торгоны замын судалгаанд бурхны шашны түүх, соёл, түүний тулгар ном зохиолын судлал чухалтай юм. Баруун орноор дамжин бурхны шашин дорно зүгт дэлгэрсэн түүхийг судлах нь баруун орны түүхэнд томоохон байр суурийг эзэлдэг манай өвөг монголчууд болох Хүннү, Сяньби, Нирун, Кидан улсуудад бурхны шашин дэлгэрсэн түүхийг цаашид судлахад давхар ач холбогдолтой хэмээн үзэв. Тиймээс миний бие энэхүү илтгэлээр бурхны шашин торгоны замыг даган Энэтхэгээс баруун оронд нэвтрэн дэлгэрсэн тухай товч өгүүлнэ.

* * * * *

Хятадын түүхийн хоёр Хань улсын үед бүрэлдэн бий болсон торгоны зам бол “Эрт цагийн хийгээд дундад зууны үед Хятадын шар мөрөн, Хөх мөрний бэлчрээс Энэтхэг, Дундад ази, Баруун Азиар дамжин хойд Африк болон Европ тивтэй холбогдох торгыг худалдааны гол эд таваар болгосон соёлын харилцааны зам байв. Торгоны замын үүсэл хийгээд хөгжил нь өрнө дорнын соёл иргэншлийн өнө удаан он жилийн түүхийг харуулдаг бөгөөд Хятад болон өрнийн соёлын харилцааны түүхийн амьд хуудас төдийгүй торгоны зам нь Ази, Европын эх газрын амин судал болохын хувьд дэлхийн түүхийн хөгжлийн гол тэнхлэг юм. Энэ л замаар эртний Сака, Чиан¹, Динлин, Тохар (манай түүхчид Юүэ жи хэмээн нэрлэдэг, угтаа Роужи хэмээх дуудлагатай Т.Ч), Хүннү, Түрэг, Уйгар, Монголчууд зүүнээс баруун зүгт нүүдэллэж, харин Грек, Араб, Ари, Согдууд баруунаас дорно зүгт нүүдэллэн ирсэн бөгөөд олон улс үндэстний мандал буурал, торгоны замын түүхийг байнга өөрчилж иржээ(х.2)².

1868 онд Германы эрдэмтэн Фердинанд вон Ричтофен Хятадад судалгаа шинжилгээ хийн, нутагтаа буцаад “Хятад орон, биеэр зорчсон аялал хийгээд

¹ Хят.羌

² 周簪苞、邱陵，丝绸之路宗教文化，1998，新疆人民出版社。

судалгааны үр дүн”(China, Ergebnisse Eigener Reisen und das auf Gegrundeter Studien, 1877-1912) хэмээх бүтээлээ хэвлүүлж, түүндээ “торгоны зам” хэмээх нэрийг анх сөхөн тавьжээ. Харин 1913 онд Францын хятад судлаач Эдвард Чаваннес (Edouard Chavannes 1865~1918) анхлан “Далайн торгоны зам” хэмээх ухагдахууныг өөрийн “Баруун Турменстаны түүхийн мэдээлэл (Historical Information of the Western Turk) хэмээх номондоо дэвшүүлсэн байна.

Өрнө хийгээд дорнын эрдэмтэн судлаачдын 100 гаруй жилийн судалгааны уйгагүй хөдөлмөр, түүнчлэн сүүлийн жилүүдэд археологийн судалгааны ажил улам гүнзгийрч, судалгааны үр дүн олноор гарч, агуулга улам баяжсаар байгаатай холбоотой торгоны замын хүрээ улам өргөжсөөр байна. Эдүгээ “Торгоны зам”-ын дөрвөн салаа байдаг хэмээн үздэг. Үүнд: нэгд, талын торгоны зам буюу Ази, Европын эх газрыг хөндлөн дайрсан хойд зүгийн талын зам. Хоёрт, Төв Азийн элсэн цөлөөр дайрах булаг шандны зам. Гуравт, зүүн өмнөд Ази, Энэтхэгээр дамжин Персийн булан, Улаан тэнгисийн өмнөд далайд хүрэх зам буюу далайн торгоны зам. Дөрөвт, Сычуань, Гуйжоу, Төвөд, Гуанши-гаар дайрч, Энэтхэг, Зүүн өмнөд азид хүрэх зам буюу баруун өмнөд торгоны зам тус тус болно. Гэвч эдүгээ хүмүүс “торгоны зам”-ыг голчлон “булаг шандны торгоны зам”-аар нэрлэж заншжээ³.

Эдүгээ хүртэл эрдэмтэд “Баруун орон”-ны хүрээ хязгаарын талаар нэгэн саналтай болж чадаагүй байна. Хятадын Хань улсын үеэс эхлэн “баруун орон”-ыг өргөн, явцуу хоёр хамрах хүрээгээр тодорхойлж ирсэн бөгөөд өргөн хүрээнд Юймэнгуань, Янгуан-аас баруун зүгт орших Дундад Азиас Европ тив хүртэл. Харин явцуу хүрээнд тэнгэр уулнаас өмнө, Күнхлүн уулнаас хойш, Сонгино даваанаас зүүн зүгт орших “36 орон”-ыг хамруулан үзэж байв. Харин Тан улсын үеийн баруун орны тухай ойлголт нь Хан улсын үеийнхээс өөр юм. Тан улсын баруун орны хүрээ хязгаар асар уудам бөгөөд Дүнхуань-аас баруун, Тэнгэр уулны өмнө хийгээд хойд этгээд, Дундад Ази, Баруун Азийн бүс нутгийг нийт баруун орон хэмээн нэрлэж байв. Энэ үеийн баруун орны явцуу хүрээ нь Хан гүрний үеийн баруун орны бэхлэлт захирч байсан өнөөгийн Шинжяны өмнөд хилийн бүс нутаг бус харин Сонгино уулын баруунаас Перс хүртэлх Дундад азийн бүс нутгийг хамруулж байв(х.1)⁴.

Ер нь баруун орны тухай судалгааны эх сурвалж голчлон хятад хэл дээр тэмдэглэгдэж үлдсэн бөгөөд бусад хэл дээр олдоц тун ховор. 19 зууны дунд үед Калхана (Kalhana) хэмээгч Энэтхэгийн Шива бурхны үнэн сүсэгт нэгэн “Ражатаражини ” (Rājataranginī) хэмээх Кашмирын түүхийг өгүүлсэн зохиолдоо баруун орны улс орнууд хийгээд Энэтхэгийн түүхийн талаар бичсэн нь эдүгээ хүртэл бүрэн хадгалагдаж, баруун орон, баруун орны бурхны шашны талаарх үнэт ховор эх сурвалж болсон байна. Англи хэл дээр эрдэмтэн Дат бол Штейн⁵ нар тус тус орчуулж олны хүртээл болгожээ. Түүнчлэн Юйтянь-ий бурхны шашны түүхийн талаар “Шизан-ы тэмдэглэл”⁶ хэмээх ном байдаг нь агуулгын хувьд Тансан хуврагийн бичсэн “Их Тан улсын баруун орны тухай тэмдэглэл” дэхь Гостана улстай бараг ижил ажээ. Энэ шастир бол түүхийн он дарааллын бичиг хэлбэрээр бичигдсэн тул Хөтянь-ий бурхны шашны он дарааллыг тогтооход чухал судалгааны хэрэглэгдэхүүн болж байна. Энэ номыг эрдэмтэн Рокхилл

³ 周簪苞、邱陵，丝绸之路宗教文化，1998，新疆人民出版社。

⁴ 高永久，西域古代民族宗教综论，1997，高等教育出版社。

⁵ J.C.Datt-The Kings of Kasmira. 3 vols. (1876-1887). M.A. Stein-A Chronicle of the Kings of Kashmir. 2 vols.(1900)

⁶ Хят.西藏传

(W.W.Rockhill) бээр 1884 онд англи хэлнээ хөрвүүлсэн байна.⁷ Хятад сурвалжийн хувьд Сы мацян-ий “Түүхэн тэмдэглэл”, “Давань-ий шастир” зэргээс гадна хятадын төрт улсын түүхэн зохиолуудын “Баруун орны шастир”, “Баруун рунь-ы шастир”, “Баруун и-гийн шастир” зэрэгт мөн тэмдэглэгдэж үлдсэн байна. Хятад сурвалжууд нэр дурдсан бүтээлүүдээр хязгаарлагдахгүй нь мэдээж бөгөөд баруун орны шашны судалгаанд бурхны сайн номлолт хуврагуудын бичиж үлдээсэн аян замын тэмдэглэл ч чухал байр суурь эзэлдэг юм.

Баруун орны түүх соёл, бурхны шашны дэлгэрэлтийн талаар тусгайлан судлаж, дэлхийн олон оронд бүтээл туурвил нь орчуулагдан, нэрд гарсан Японы их эрдэмтэн Хатана Рёотай (Hatani Ryotai) “Баруун орны буддын шашин” хэмээх бүтээлдээ “Эдүгээ хүртэл өрнө, дорныг холбогч “худалдааны зам” хэмээн нэрлэдэг замд нүүдэлчин улс орнуудын зүүн зүгт Хянганы нуруунаас баруун зүгт Карпатын нуруу хүртэл эзэрхэж байсан өргөн уудам газар нутаг (Монгол, Жүнхэрийн хөндий, өмнөд Оросын их тал газрыг зааж байна); Талын Зам болон Евразийн төв (Монгол болон түүний баруун өмнө, Зүүн Туркменстан, Ираны өндөрлөг, Арабын хойг гэх мэт) -өөр дайрах элсэн цөл “Элсэн цөл ногоон булаг шандны зам” хийгээд эмийн зүйл, хүнсний амтлагч зэргийг тээвэрлэн, хадгалах зориулалт бүхий “далайгаар тээвэрлэх амтлагчийн зам” -ууд багтана. Эдгээрээс “элсэн цөл булаг шандны зам” (үүнээс Таклахамын цөлийн хязгаар лугаа залгагдсан хэсэг, Тэнгэр уулын өмнөд замын баруун бүс нутгийн өмнөд зам болон баруун орны хойд зам) нь бурхны шашны баруунаас дорно зүгт дэлгэрэх гол зам нь юм...Оршин суугчид нь хойд зүгийн нүүдэлчдийн халдлагаас хамгаалан, эргэн тойрондоо хана хэрэм босгон, хот балгадын орнуудыг үүсгэжээ. Томоохон булаг шандын орнууд газар тариалан эрхлэхээс гадна гар урлалын зүйл үйлдвэрлэхийн зэрэгцээ дайран өнгөрөх худалдаачдад зориулсан гадна зээлийг нээн ажиллуулна. Түүнээс гадна хот балгадын орнууд оюуны амьдралыг харуулах тахилын сүм, хийд орон байгуулан худалдаа, улс төр, шашин соёлын онцлогийг илтгэсэн шинжтэй. Худалдааны хөгжлийг даган, эдгээр хот балгадуудад гаднаас ирсэн соёлын биет хийгээд биет бус хүчин зүйл тухайн газар нутгийн онцлогуудтай нэгдэж, шинэ төрлийн соёлыг бүрдүүлэхийг зэрэгцээ ойр хавийн бүс нутагт тэрхүү шинэ соёлын үрийг цацаж байв”⁸ хэмээн тэмдэглэсэн байдаг. Үнэхээр ч торгоны зам дагуу орших баруун орон бол түүхийн бүхий л цаг үед олон улс үндэстнүүдийн шашны соёлын харилцааны гол зангилаа байв.

Хятадын нэрт эрдэмтэн, угсаатан судлаач Гао Юнжю соёлын газар зүйн хувьд баруун орныг нийт зургаан бүсэд хуваасныг дурдвал: Нэгд, Амударьяа мөрнөөс урагш дээд хийгээд дунд урсгал, урьд Бактри хэмээн нэрлэж байсан бөгөөд Тохаристан ч хэмээдэг. Түүхэнд энд бурхны шашин анх дэлгэрсэн байдаг. 7-р зуунаас хойш Арабууд энэ газар нутгийг Хорасан хэмээн нэрлэх болжээ. Хоёрт, Амударьяа мөрний хойд Кашкадарья болон Зерафшан мөрний хоорондын нутаг. Түүхнээ энэ газрыг Согдиана буюу Согд хэмээн нэрлэдэг байв. Гуравт, Арал тэнгисийн өмнөд эрэг буюу Хорезм юм. Эрт цагт Кангюй хэмээдэг байв. Дөрөвт, Долоон голын орчмыг шашин дэлгэрэлтийн хувьд нэгэн тусгаар соёлын бүс нутагт хамруулж болно. Тавд, Тэнгэр уулын өмнө бүс нутаг, түүхэнд Таримын талыг голлон нэрлэдэг. Шашин дэлгэрэлтийн чухал бүс нутаг юм. Зургаа, Тэнгэр уулын

⁷ 羽溪了諦(Tora Haneda), 西域之佛教, 贺昌群 译, 1999 商务印书馆。

⁸ 贾晓梅译, 丝绸之路、佛教东渐及西域探险史, 丝绸之路佛教艺术大展, 1996, 日本东京国立博物馆。

хойд бүс нутаг”⁹(4) Ийнхүү судлаач эрдэмтэд газар зүйн төдийгүй соёлын хувьд баруун орны хүрээ хязгаарыг тогтоож, нарийвчлан судалсаар байна.

Одоо Бурхны шашин МЭӨ I - МЭ XVI зуун хүртэлх баруун орнуудад хэрхэн дэлгэрсэн талаар товчлон өгүүлье.

Бурхны шашин Шагъямуни бурхан нирваан дүр үзүүлснээс хойш олон жилийн дараа Энэтхэгийн хил хязгаарыг даван, бусад улс орнуудад дэлгэрсэн ажээ. МЭӨ245 онд Энэтхэгийн Маура төрт улсын (МЭӨ322-185 Тогосон хаан) Ашока хааны ивээлээр Патилапутра хотноо (өнөөгийн баруун хойд Энэтхэгийг Патна хот) Бурхны шашны 3 дахь удаагийн их чуулган болж, Бурхны шашин Энэтхэгийн хөрш зэргэлдээ Кашмир, Гандхара (өнөөгийн Пакистаны баруун хойд хязгаарын Байшава орчим) нутагт дэлгэрсэн байна. Гандхара нь Энэтхэгийн бурхны шашны сэтгэлгээ Грекийн урлагийн хэлбэр лүгээ нэгдэж, хүмүүс бурхны хөрөг дүрийг бүтээх болсноор хожмын Гандхарын бурхны шашны алдарт урлаг бий болсон юм. Удалгүй энэ төрлийн урлаг өмнөд хязгаарт түгэн дэлгэрч, түүний нөлөө нь Хятадын Юньган болон Лунмэнь-ий чулуун агуйд тусгалаа олсон байдаг. Грекийн хойчсын ноёрхож байсан Бактри улсын хаан Мэнандрос (багцаагаар МЭӨ125-95 оны хооронд хаан ширээнд сууж байсан) бурхны шашинд сүсэг олсон нэгэн байсныг түүхийн баримтууд гэрчилдэг.

Хойт зүгийн Сака үндэстэн МЭӨ139 онд өнөөгийн Ираны Систан орчим үзэгдэх болжээ. Тэд Грекийн хамгийн сүүлийн үр хойчсийг нухчин дарсаны дараа Диодотус хаант улсыг байгуулав. Сака үндэстэн МЭӨ174-160 оны хооронд Хятадын Ганьсү мужийн баруун зүгээс Или мөрөн тийш нүүж байсан Тохарчуудад шахагдан Или мөрнөөс дахин өмнө тийш нүүдэллэх явцдаа нэг салбар хүмүүс нь өмнө зүгт нүүх замдаа Талимын хөндийн өмнө хэсэгт орж, хожмын Хотон сака үндэстнийг бүрдүүлжээ. Өөр нэгэн салаа нь МЭӨ62 онд баруун хойд Энэтхэг хүртэл тэлээд, өнөөгийн Кашмирт бурхны шашныг үндэс болгосон хаант улсыг байгуулжээ. Энэ орноо хожим Кушаны хаант улсын Канишка хааны ивээл доор бурхны шашны түүхнээ ихэд алдаршсан 4 дэхь удаагийн бурхан шашны их чуулгыг хуралдуулсан байна.

Дээр дурдсан Тохарчууд нэгэн төрлийн иран хэлээр ярилцдаг байсан бөгөөд МЭӨ173 оны орчим Ганьсү-гийн баруун хойд нутгаас Хүннү нарт хөөгдөн, эхлээд Сака нарын амьдарч байсан нутагт ирээд, МЭӨ160 оны орчим тэндээсээ мөн Вүсүнх нарт хөөгдсөн байна. Тохар нар өмнө зүг Амударьяа мөрний өмнө орших Бактри хүртэл нүүдэллэн ирээд, Энэтхэгийн баруун хойд хүртэл хүчээ зузаатгаж чадсан байна. Хожим Тохарчууд улс төр хийгээд үндэстний хувьд Сака нартай холилдон, энэ хоёр үндэстнийг тодорхой зааглах аргагүй болон уусчээ. Тохарагийн таван аймгийн нэг болох Кушанчууд хожим ноёлох байр суурийг олж, түүхэнд алдар нэрийг олсон Кушаны хаант улсыг байгуулсан түүхтэй. Энэ улсыг үндэслэгч нь Кужула Кадфиз VII-р зуунд Бакриад нийслэлээ байгуулжээ. Кадфиз хаан төр захирч байх үед бурхны шашин өмнөд хязгаарын Хөтянь (Хотон)-д нэвтэрчээ.

Баруун орноос анх Хятадад бурхны шашин анх дэлгэрсэн тухай эрдэмтэн судлаач нарын хүлээн зөвшөөрдөг нэгэн яриа байдгийг Монголын их эрдэмт Гүн Гомбожав “Хятадад бурхны шашин дэлгэрсэн түүх” зохилдоо тэмдэглэсэн нь: “Их Хань улсын Минди хаан Юунпин (58 оны сүүлээс 75 он хүртэл)-гийн наймдугаар

⁹ 高永久, 西域古代民族宗教宗綜論, 1997, 高等教育出版社.

онд Нангиад нь бурхны шашны эхийг олжээ. Юунпингийн гуравдугаар оны шинийн сайны шөнө хаан: “Гурван тохой илүү турагтай, алтан лагшнаар бидэрлэсэн, нарны гэрэл цацруулагч нэгэн бээр огторгуйн замаас орд харшны алтан дээврийн өмнө залран ирэв” хэмээн зүүдэлжээ. Маргааш нь тэр зүүдний талаар түшмэлүүдээсээ асуухад, түшмэл Фү-И хэмээгч нь: “Өмнө нь Жоу-гийн цагт Энэтхэгт Сэрэн дэлгэрсэн бурхан¹⁰ хэмээгч нэгэн аршийн бие нь гурван тохой илүү, арьс нь алтан өнгөтэй гэрэл цацруулсан, огторгуйгаар яван чадагч байжээ. Хааны зүүд түүн лүгээ холбоотой болохыг айлтгая” хэмээв. Тэгээд хаан хуучин ном судрыг уншин болгооход Жоужао хааны үеийн эш бошго үзүүлснийг олж, машид баясчээ. Ийнхүү хаан бээр Ван Зүн¹¹-г тогтоосон тааллыг олуулахаар Энэтхэг орноо илгээв” Тэр үед Нангиад орноо шашин дэлгэрэхүй цагтаа буусныг болгоож, Одсрүн-гийн язгуурт архад Мадонга¹² болон Дафалан¹³ хоёр нэгэн цагаан моринд Бурхан багшийн зурмал хөрөг хийгээд зарим нэгэн эрхэм зарлигийг ачаад, Нангиад уруу залрах замд Хятадаас томилогдсон элчтэй тааралдаж, ийн хамтдаа Нангиад орноо зорьжээ. Архад элдэв рид шидийг үзүүлж, хаан нөхөд сэлт бүгд бишрэн баясчээ. Уг нутгийн бомба нар үүнд илтэд дургүйцэж, бомба, бурхны номтон хоёрын аль нь сайнаа үзүүлэхээр мэтгэлцсэн боловч бомба нар ялагдаж, номыг нь галд түлсэн гэх түүхийг би бээр (Гүн Гомбожав) «Таван үзүүрт уулын гарчиг» хэмээх номдоо дэлгэрэнгүй бичсэн болно” хэмээн тэмдэглэсэн байдаг¹⁴. Мөн Хятадын Зүүн Хань улсын Жяньхө-гийн IX-р онд (147 он) Тохар улс (Кушан улс)-ын лам Зилүгаачаа Хятадад ирсэнээс хойш 40 жилийн хугацаанд Дүйпаг¹⁵, Дэдүл¹⁶, Жи яао¹⁷, Жүфошуо¹⁸, Канжюй¹⁹ зэрэг алдартай хуврагууд Хятадад ирж бурхны шашныг дэлгэрүүлэн, дуун хөрвүүлэх их үйлсийг өрнүүлжээ. Нангиад орноо ирсэн Энэтхэгийн эдгээр дуун хөрвүүлэгчид бүгд Энэтхэгийн одон орон, тоо бодлого, рид хувилгааны талаар өргөн мэдэгдэхүүнтэй номын мэргэд байсан бөгөөд Хятад, Энэтхэгийн соёлын харилцаа бодитойгоор хөгжихөд их нөлөө үзүүлсэн байна. Мөн Энэтхэгийн Гүмаашри нь Гүй Зи буюу өнөөгийн Шинжяны Күчө-өөс Чан ань хүртэл улсын их багш хэмээн хүндлэгдэх болжээ. Ийнхүү Канишка хааны үед (127-151 он) бурхны шашин Шинжяны орчим дэлгэрэхийн зэрэгцээ Хятадын төв хэсэгт нэвтэрсэн байна.

Согдууд баруун орны түүхийн тавцанд маш идэвхтэй байр суурь эзэлсэн үндэстний нэгэн байв. Тэд бурхны шашнаас гадна зорастанизм, манихейн, несториан болон исламын шашныг ч шүтэж байжээ. Согдуудын амьдарч байсан Согдиана бүс нь Дундад Азийн төв бүс нутаг бөгөөд бүхий л шашин зэргэмжээр энэ нутагт нэвтэрсэн байдаг. Тиймээс ч Согдууд бусдаас түрүүлж аливаа шашинтай холбогдож, мөн эдгээр шашныг гадагш дэлгэрүүлэх үүрэг хүлээж байв. Эдгээр шалтгааны улмаас Узбекистаны Самарканд болон Бухарт төвлөж байсан эртний Согдын нутаг дэвсгэрт бурхны шашин тун эрт байр сууриа олжээ. Хятадын түүхэн баримтуудад дурдсанаар 148-396 оны хооронд Аньгуо (Бухар), Кангуо (Самарканд) орнуудаас бурхны олон хуврагууд Хятад орноо хүрэлцэн ирж, бурхны

¹⁰Хят.佛陀 (Fotuo). Бурханы шашинг үндэслэгч.

¹¹Ван Зүн нь Хят.王尊 (Wang Zun).

¹² Архад Мадонга нь Хят.阿罗汉摄摩腾 (Aluohan Shemoteng).

¹³ Дафалан нь Хят.竺法兰 (Zhu Falan). Англ. Dharmaratna

¹⁴ Гүн Гомбожав, Хятадад бурхны шашин дэлгэрсэн түүх, Орч.Т.Чулуун-Эрдэнэ, 2016 он, Соёмбо Принтинг.

¹⁵Хят.安世高

¹⁶ Хят.安玄

¹⁷ Хят.支曜

¹⁸ Хят.竺佛朔

¹⁹ Хят.康巨

ном судрыг хөрвүүлэх ажилд оролцож байсан тэмдэглэл бий. 576 онд тус орон баруун Туркменстанд харъяалагдсаны дараа ч бурхны шашин хүчтэй хэвээр байв. Харин 7 зууны эхэнд бурхны шашин манихеизм шашин болон түүхнээ дахин толгой өндийсэн зороастризмын шашны шахалтад орсон байна. 705-715 оны хооронд Арабын жанжин Кутайба нь Исламын дайчдыг удирдан Хорасанаас Мавераннахр²⁰ (Трансоксиан) уруу дайран ороход Фергана хөндийн ард түмэн (тухайн үед баруун Түрэгийн захиргаанд байсан) 712 оноос эхлэн Арабуудыг эсэргүүцэн 100 гаруй жил болоод 715 онд Тан улсын Гао Шяньжи-гээр удирдуулсан цэргийн ангийг Арабын их дайчид лугаа Таласын хөндийд тулалдан ялагдсаны дараа хойд Таласын газар нутаг Арабуудын гарт оржээ. 893 онд Талас нутаг Исламын шашинт Саманид хаант улсын Исмаил бэн Ахмед (Ismail ben Ahmad)-ын ноёрхолд дахин орсоноор Исламын шашин Кашэнь²¹ болон Таримын хөндийд нэвтрэх их үүдийг нээсэн байна. 10 зууны үед Кашэ (өнөөгийн Кашгар хот)-д бүр мөсөн нэвтэрчээ²².

Канишка хаанаас хойш өмнөд нутагт бурхны шашин дэлгэрсэн нөхцөл байдлын талаар Хятадын Фашянь болон Тансан хуврагууд аян замынхаа тэмдэглэлд маш тодорхой тэмдэглэн үлдээсэн байдаг. Энэ хоёр хувраг 5-7-р зуунд тус тус баруун орны өмнөд нутгаар дайрч, Энэтхэг орноо аялан, “Бурхны орны тэмдэглэл” болон “Их Тан улсын баруун орны тухай тэмдэглэл”-д бурхны шашин дэлгэрсэн талаар дэлгэрэнгүй өгүүлсэн нь бий. Миний бие 2018 онд “Их Тан улсын баруун орны тухай тэмдэглэл”-ийг хятад хэлнээс монгол хэлэнд хөрвүүлсэн ба дэлгэрэнгүй агуулгыг тэндээс уншиж болно.

Монголчуудын хувьд бурхны шашин Хүннүгийн үеэс Монгол нутагт ямар нэг хэмжээгээр нэвтэрч эхэлсэн ба Жужан буюу Нирун улсын үе болоход хөгжин гүнзгийрсэн байна. Тийнхүү Нирун улсад бурхны шашин дэлгэрэхэд тухайн үеийн нийгмийн дэвшил хөгжил, зарим хэрэгцээ шаардлага, хөрш улс орнуудад бурхны шашин түгэн дэлгэрч байсан зэрэг хүчин зүйл нөлөөлжээ²³. Манай нэрт түүхч асан Г.Сүхбаатар: “420-479 оны үед “эрдэмтэй хүмүүс олон буй” гэж хятад сурвалж бичигт тэмдэглэсэн нь зөвхөн бичиг мэддэгээр барахгүй, эрдэм номтой хүмүүс нирунчуудын дунд байсныг цохон хэлжээ. Нирун улс Дармаприя гэдэг ламыг төрийн багшаар томилон, 3000 өрх соёрхож, бурхны шашныг төрийн шашин болгосон болохоор бурхны шашныг дагалдан, бичиг дэлгэрсэн байх ёстой. Ингээд Нирун улсын дотор бичгийн соёл нилээд хөгжиж, эрдэмтэй хүмүүс, бичгийн сайд буй болсон байна. Хятадын Лоян хотын нэгэн сүмд сууж байсан энэтхэг лам Ратнаманти тэр хотод аялан очсон нэгэн нирун хүмүүнийг түмэн хуйлаас ном уншсан хүнд ч давагдахааргүй эрдэмтэй хүн гэж ихэд хүндэтгэн, харь (хятад бус) хэлээр өдөржин ярилцдаг байв. Энэ нь магадгүй санскрит хэл байсан байх²⁴ (х.117) хэмээн бичсэн байдаг.

Түрэг улсын Туву хаан (572-581 он)-ы үед бурхны шашин Түрэгт хэдийн нэвтэрчээ. Хятад хэлний сурвалжид тэмдэглэснээр тухайн үед Умард Чи улс (550-577 он)-ын хувраг Хүй Линь Түрэгт баригдаж ирээд Туву хаанд Чи улсын хүчирхэг байгаа нь бурхны сайн номонд сүсэглэсний үр юм хэмээн айлтгасан бөгөөд

²⁰ Төв Ази дахь түүхэн газар нутаг байжээ. Одоогийнхоор хэлвэл Узбеки орны ихэнх нутаг, Тажик, Хиргисийн баруун хэсэг, Туркменийн зүүн тал, Хасаг орны өмнө үзүүрийг хамарч байв.

²¹ Англ. Qeshqer Wilayiti

²² 耿世民, 佛教在古代新疆和突厥、回鹘人中的传播, 新疆大学学报, 1978 (2) :69-76

²³ Монгол улсын түүх: Тэргүүн боть, 2004, УБ.

²⁴ Г.Сүхбаатар. Монголын эртний түүх судлал 1 боть. Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа гарвал. 2000.УБ

цаашид бурхны сайн номлолын нарийн учир шалтгаан, үрийн талаар сургаал номыг хаанд тайлбарласнаар хаан ч бурхны шашинд сүсэг орж, өөрийн газар нутагт нэгэн суварга бариулж, Умард Чи улсад элч томилон, ном судар авчруулсан байна. Умард Чи улсын Гао вэй хаан (565-577) тухайн үеийн олон үндэстэн орны хэлийг гаргуун сайн эзэмшсэн Лиү Шичинь хэмээгч хүнээр “Гаслангаас нөгчсөн нь”²⁵ судрыг түрэг хэлнээ хөрвүүлүүлж, Түрэгийн хаант улсад өргөсөн байна. Туву хаан түүнээс хойш сахил авч, суварга тойрон гороолоох болсон гэдэг.

Тухайн үед Түрэгийн хаант улсад бурхны шашин номыг дэлгэрүүлэгч нь Хүй Линь ганцаар байсангүй, түүнчлэн Гандхара орны их хувраг Жингупта Умард Жоу улс (557-581 он)-ын Вүди хаан Зиэнь дө-гийн гуравдугаар он (574 он)-д бурхны шашныг хориглох үед Түрэгээр дайрч нутаг буцахаар төлөвлөж байснаа Туву хааны хүсэлтээр Түрэгт арав гаруй жил саатан морилж, тэндээ бурхны шашныг ихэд дэлгэрүүлсэн. Тэр цагт Умард Чи улсын хувраг Бао Шиэнь²⁶ тэргүүтэн арван нэгэн хувраг 575 онд Энэтхэгээс ном судар залаад буцах замдаа хоёр зуун жар гаруй санскрит судрыг аван Түрэгийн нутагт иржээ. Тэд Умард Жоу улс Умард Чи-г дарж, бурхны сайн номлолыг мөхөөн доройтуулж буй мэдээг сонсоод хэсэг хугацаанд Түрэг улсад саатахаар шийджээ. Түүнчлэн Жингупта лугаа хамт Энэтхэгээс дайж авчирсан судар номоо ангилан цэгцлэх их ажлыг эхлүүлсэн бөгөөд Сүй улс (581-618 он) Умард Жоу улсыг дарж, бурхны шашин дахин сэргэн дэлгэрч буйг дуулаад 581 онд нутагтаа буцжээ. Энд өгүүлэх тэмдэглэл нь манай монгол улсад 1956 онд Архангай аймгийн Их Тамир сумын нутагт олдсон Түрэгийн нэгдүгээр хаант улсын Татпар (Макан тегин) хааны дурсгалд зориулан, 582 онд босгосон дурсгалын хөшөөний судалгаагаар батлагдсан юм. Оросын эрдэмтэд болох Лившиц В.А., Кляшторный С.Г нар Макан Тегин буюу Татпар хаан бол дээр дурдсан Туву хаан юм хэмээн тэмдэглэсэн байдаг.

Мөн баруун Түрэг нилээд эрт бурхны шашинтай холбогдоно. Баруун Түрэгийг үндэслэгч Истеми хаан буюу Түрэгийн Буман хааны дүү Или голын баруунш газрыг харъяандаа оруулж, тэнд олон жил суурьшсан байна. 565 оноос хойш баруун Түрэг Дундад Азийн Согдын орчим, Афганы хойд тал болон Энэтхэгийн баруун хойд талыг эзэмшилдээ оруулжээ. Тэдгээр эзэмшил газар нь эртнээс бурхны шашин хүчтэй дэлгэрсэн газар нутаг байсан тул бурхны шашинд орох нь зүйн хэрэг байлаа.

Наймдугаар зууны дунд үед түрэг хэлт аймаг болох Уйгарууд Түрэгийн халааг авч Монгол газар нутагт Уйгарын хаант улсыг (744-840 он) байгуулжээ. Уйгарууд бурхны шашныг бүрэн авсан нь 9 дүгээр зууны дунд үед баруун тийш нүүн Шинжянд ирсэнээс хойш явдал юм. Жишээ нь 629 онд Тан улсад алба өргөсөн Уйгарын нэгэн толгойлогчийн нэрийг “бодьсадва” хэмээн дууддаг байсан мэдээ бий. Бодьсадва нь “гэгээрсэн” хэмээх утгатай болохыг бид мэднэ. 9 дүгээр зууны дунд үед Уйгарууд Шинжянд ирсэний дараа тухайн нутгийн оршин суугчдын нөлөөгөөр нүүдлийн аж ахуйгаа аажмаар гээж, суурьшмал хот суурингийн, тариалангийн амьдралын хэв маягтай болохын зэрэгцээ аажимдаа мөнхүү бурхны шашинд сүсэг орж эхэлжээ.

Уйгарууд бурхны шашинд орсоны дараа уйгар хэлээр маш олон тооны бурхны ном судар орчуулсан байдаг. Бурхны эснэсэн их сайн цаг (дүйцэн гэдэг)-т олон сүсэгтэн сүм хийдийн ойролцоо чуулдаг газар уйгар хэлээр бурхны шашны

²⁵ Хят.涅槃经

²⁶ Хят.宝暉

агуулгатай, маш сэтгэл хөдөлгөм ши жүжиг тоглодог байв. Түүнчлэн тухайн үед Уйгарын хааны ордныхон болон эрх ямбатан, язгууртнууд өөр зуураа өрсөлдөн, сүм хийдэд өглөг өргөх эс бөгөөс сүм хийд байгуулах, бурхны хөрөг дүр урлах, хүн хөлсөлж бурхны ном судар хуулбарлан бичүүлэх зэргээр бурхны шашны хувьд их буян үйлддэг байв. Гаочан хавийн орон газар бурхны шашны сүм хийдийн туурь, мөн Мянган бурхны агуйн олдвор болон бусад бурхны шашны холбогдолтой эд өлгийн зүйл байдаг нь тухайн үеийн шашин дэлгэрэлтийн үеийн батладаг.

10-р зууны үед өмнө зүгийн Кашгар төвтэй Хар хаан хаант улс исламын шашинд орж, 11-р зуун гэхэд Исламын шашны хүч дорно зүгт Хөтянь хүртэл дэлгэрсэн ба сүсэг ихт Гаочаны Уйгарын хаант улсын ширүүн эсэргүүцэлтэй тулгарч, 2 зууныг дамнасан урт удаан хугацаанд Күчөгийн хилээс цааш давж чадаагүй юм. Харин 12-р зууны үед тухайн үеийн Гаочан-ы Уйгарын хаан Балкик арт Тэгин (Barquk Art Tegin) өөрийн хүсэлтээр Чингис хааны харъяанд орсоноор Чингис хааны өглөгт багтаж, эзэмшил газраа хэвээр хадгалж чадсан бөгөөд хаант улсынх нь уламжлалт амьдралын хэв маягаа бараг хадгалж үлджээ. Тиймээс ч бурхны шашин Уйгарын хаант улсад бүхэлдээ давамгайлах байр суурьтай хэвээрээ байв. Энэ үед Уйгарын буддын шашны их хувраг болох Гарунадас²⁷, Галсан²⁸, Биланашили²⁹ зэрэг их хуврагууд Хятад хэл дээрх төвд судрыг эмхлэх ажилд оролцож байсан мэдээ бий.

Киданчууд Тан улсын үед Уйгаруудтай харилцаа тогтоосон хэмээн түүхэнд тэмдэглэгдсэн байдаг. Уйгарын хаан Пейло ойр орчмын газар орныг эрхшээх цагт Киданчууд ч тэдний захиргаанд орсон бөгөөд Уйгарчууд алба гувчуур авах, мөн төрийн элчийг илгээх зэргээр нягт харилцаа холбоотой байсан нь Киданчууд Уйгараас бурхны шашны нөлөө авч, бурхны шашин дэлгэрэх үндэс болсон байна.

Эцэстээ 15-р зууны орчим Шинжяны бурхны шашин Исламын шашинд байраа тавьж өгсөн юм. 16-р зууны үеийн Уйгарын түүхийн алдарт зохиол “Рашид аддины судрын чуулган”-нд Турпын орчим зөвхөн зүүн Цагаадайн хаан Хизир Хожа (Hizir Hoja 1383-1399 он)-ий үед л Исламын шашныг хүчээр авсан хэмээн тэмдэглэсэн байдаг. Мин улсын үеийн Чөнъ Чөн³⁰, Ли Шянь³¹ “Баруун орны Фаньгуо -гийн цадиг³² - т энэ газар бурхны шашинд сүсэглэгчид байх боловч ихэд доройтон буурсан талаар тэмдэглэжээ.

Энэтхэгийн бурхны шашин хил хязгаараа тэлэн дундад Азид нэвтэрч дэлгэрсэн зам нь эртний торгоны замтай яг адил юм. Тиймээс торгоны замыг “бурхны шашны зам” хэмээн нэрлэх нь ч бий. МЭӨ 245 онд Энэтхэгийн Ашока хаан бурхны шашны 3 дахь удаагийн их чуулган хуралдуулсан цагаас бурхны сайн номлол Энэтхэгийн хөрш зэргэлдээ Кашмир, Гандхара нутагт анхлан дэлгэрч, цаашлаад Кашмир, Тохара, Согд, Нирун, Кидан, Түрэг, Уйгарын газар нутагт нэвтэрч, өргөн цэцэглэсэн байна. Бурхны шашин баруун орнуудад нэвтрэхдээ тухайн улс орны ард түмэн үндэстний унаган соёлоос шингээн авч, агуулга, бүтэц, хэлбэр нь янз бүрийн түвшинд өөрчлөгдөгдөж, бурхны шашны соёлын агууламжтай олон талт соёлыг бүрэлдүүлсэн бөгөөд цаашлаад зүүн зүгт тархсаар Хятад улсад Зүүн Хань

²⁷ Хят.迦鲁纳答思

²⁸ Хят.安藏 Гүн Гомбожав нэрийг ийн хөрвүүлсэн.

²⁹ Хят. 必兰纳识里

³⁰ Хят.陈诚

³¹ Хят.李暹

³² Хят.西洋番国志

улсын эхэнд нэвтэрч, Гансү-гийн Хөши кооридор, Лунши бүс нутгаар дамжин бурхны шашны соёлыг авсан байна.

Бурхны шашин ийн хүчтэй дэлгэрэхэд бурхны шашинд чин сүсэгт, лам хуврагуудын үүрэг их бөгөөд эдгээр хуврагуудын намтар, үйлсийн талаар тусгайлан судалбал мөн сонирхолтой юм. Бурхны сайн номлол баруун оронд нэвтэрсэн түүхийн баримт голчлон хятад хэл дээр тэмдэглэн үлдсэн тул хятад сурвалжийг түшиглэн цаашид баруун орны түүхэнд томоохон байр суурийг эзлэж байсан манай өвөг монголчууд болох Хүннү, Сяньби, Нирун, Кидан улсуудад бурхны шашин хэрхэн дэлгэрсэн талаар цаашид гүнзгийрүүлэн судлууштай байна аа.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээр:

1. Гүн Гомбожавт (2016), Хятадад бурхны шашин дэлгэрсэн түүх. Орч.Т.Чулуун-Эрдэнэ УБ. 2016 он.
2. Монгол улсын түүх: Тэргүүн боть, УБ. 2004.
3. Сүхбаатар.Г, Монголын эртний түүх судлал 1 боть. Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа гарвал. УБ., (2000)

Хятад хэл дээр:

- 1 高永久, 西域古代民族宗教综论, 1997, 高等教育出版社。
- 2 耿世民, 佛教在古代新疆和突厥、回鹘人中的传播, 新疆大学学报, 1978 (2):69-76。
- 3 贾晓梅译, 丝绸之路、佛教东渐及西域探险史, 丝绸之路佛教艺术大展, 1996, 日本东京国立博物馆。
- 4 羽溪了谛 (Tora Haneda), 西域之佛教, 贺昌群译, 1999, 商务印书馆
- 5 周簪苞、邱陵, 丝绸之路宗教文化, 1998, 新疆人民出版社。

ABSTRACT

The Silk Road was created during the Western and Eastern Han Dynasty in China in the early and mid-century period. Silk from the regions of the Yellow River and the Yangtze river was a major trading product and reached India, Middle East and through Western region destined North Africa and Europe. The silk road became not only main trade path but also was a bridge for the Eastern and Western countries as cultural affiliation, thus Buddhism is widely-spread in the Asia. Studying history, culture of Buddhism and it's literature is essential for the Silk Road Research. In this research I also consider that it is important to study the history of spreading Buddhism among our ancestors the Hunnu, Xianbei, Nirun and Khitan people. Hereby, I present a short summary of the history how Buddhism was spread from India through West Region.